



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 11 сарын 11 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

## ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 60.2.9 дэх заалт нэмсүгэй:

“60.2.9.Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламж.”

**2 дугаар зүйл.**Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4.4 дэх заалтын “, мэргэжлийн хяналт” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.**Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.11 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР